

## ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ:

## ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ

**Н**ээлттэй Нийгэм Форум нь Монголын Хуульчдын Холбооны Эрүүгийн эрх зүйн хороотой хамтран “Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал” сэдэвт 8 цуврал хэлэлцүүлгийг мөрдөгч, өмгөөлөгч, прокурор, шүүгч, их дээд сургуулийн багш нар, хохирогч хамгааллын чиглэлээр ажилладаг ТББ-ын ажилтан зэрэг нийт 150 орчим мэргэжилтнийг оролцуулан 2018 оны 4-р сарын 20-ны өдрөөс 5-р сарын 22-ны хооронд зохион байгуулсан билээ. Хэлэлцүүлгийн үеэр Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлыг авч хэлэлцлээ.

Эхний 6 цуврал хэлэлцүүлгийг тодорхой ажил мэргэжлийн хүрээнд хийсэн бол сүүлийн хоёр хэлэлцүүлгийг бүх талын төлөөллийг оролцуулан зохион байгуулснаараа онцлогтой. Үүний дүнд хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой тулгамдаж буй асуудлыг аль болох олон талын оролцоог ханган тодорхойллоо. Хуульчид, хууль сахиулагчдын өмнө тулгарч буй асуудал нь хуулийг нэг мөр хэрэгжүүлэх, асуудлыг шийдвэрлэх оновчтой шийдлийг эрэлхийлэхэд оршиж буй тул гарсан бүхий л санал шүүмжийг нэг бүрчлэн тусгахыг эрмэлзсэн болно. Үүний зэрэгцээ бүх асуудалд бус зарим нэгд зарчмын зөрүүтэй байр суурь, эсхүл тодорхой санал гарсныг тусгасны улмаас бичиглэл, найруулгын хувьд нэг мөр болоогүйд хүлцэл өчье.

Хэлэлцүүлгээс гарсан тулгамдсан асуудлыг нийтлэг болон тусгай асуудлууд хэмээн хоёр бүлгээр танилцуулж байгаа бөгөөд дээрх 4 хуулийн хүрээнд нийтлэг 90, тусгай 266 тулгамдсан асуудлыг тодорхойлоод байна. Энэхүү хуулийн шүүмж нь эрүүгийн хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль хэрэгжүүлэх албан тушаалтныг чадавхжуулах, хуулийг нэг мөр хэрэгжүүлэх дүрэм журам, удирдамж, заавар зөвлөмж, гарын авлага боловсруулахад хувь нэмэр болно гэдэгт найдаж байна.

Хэлэлцүүлэгт оролцсон хуульчид, хууль сахиулагчид, иргэний нийгмийн ажилтнуудын нэрсийг хавсаргасан болно.

## Нэг. Нийтлэг асуудал

- 1.1. Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг хийхдээ Ром-Герман болон Англи-Саксоны эрх зүйн бүлийг холин, аль бүл дээр тогтохоо шийдэж чадаагүй байдлаар боловсруулсан нь зарим талаараа эрх зүйн чадамжгүй болоход хүргэж байна.
- 1.2. Эрх зүйн хувьд холимог байж болох ч дэс дараалал, зөв зүйтэй боловсруулж, Монгол Улсын нөхцөлд хангалттай тохируулаагүй байна. Тухайлбал, гэмт хэргийн гомдол мэдээллийг шалгах хугацаа богино байгаа нь Монгол шиг өргөн уудам газар нутагтай, хэрэг хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллага хоорондын зохицуулалт сул байгаа энэ нөхцөлд тохиромжгүй байна. Түүнчлэн Прокурорын зөвшөөрөл өгөх эрх хэмжээг нэмэгдүүлэн, шүүгчийн эрх хэмжээг тодорхой хэмжээнд бууруулсан байна.

**Санал:** Гомдол мэдээлэл шалгах хугацааг хуучнаар буюу 14 хоногоор сунгадаг уламжлалаа сэргээх шаардлагатай. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь зөвшөөрөл шаардлагатай ажиллагааг шүүхийн хяналтаас гадуур буюу прокурорт хамааруулсан байдалд харилцан өөр байр суурьтай болно. Прокурор нь яллах чиг үүргийг хэрэгжүүлэгч байхын зэрэгцээ мөрдөн шалгах ажиллагааг чиглүүлэн удирдаж байна. Энэ нь мөрдөгчийн цагаатгах талын нотлох баримтад ач холбогдол өгөхгүй байх магадлалтай. Үүний улмаас хүний эрхийн асуудал хөндөгдөж байна.

- 1.3. ЭХХШТХ-ийн зорилт нь “... гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино” гэж тодорхойлсон хэрнээ мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэх гол субъект болох мөрдөгчийн эрхийг хязгаарласан. Мөрдөн шалгах ажиллагаа тасралтгүй явагдах зарчим алдагдсан, хүний эрхийг хангах нэрийн доор албан тушаалтан, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн дархлааг нэмэгдүүлсэн хууль болсон.
- 1.4. Хуулийн хэлэлцүүлэг, хуульд санал өгөх ажилд мөрдөгч, хэрэг бүртгэгч зэрэг практик ажилтнуудын оролцоог хангахад анхаарах нь зүйтэй. Мөн өмнөх хуулийн зарим нэг заалтыг шинэ хуульд нэмж тусгах шаардлагатай бөгөөд энэ нь ухралт биш, харин хуулийн зохицуулалтыг бодит байдалд нийцүүлэх алхам юм.
- 1.5. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цагдаа, прокурор, шүүх байгууллагын хамтын ажиллагаа дутмаг байгаа нь хуулийн үзэл баримтлалд нийцээгүй үр дүнд хүргэж байна. Тиймээс хамтын ажиллагааг сайжруулах, хэргийг шийдвэрлэхдээ цахим арга хэрэгсэл (и-мэйл, вэбсайт, дотоод сүлжээ г.м) ашиглах, технологийн дэвшлийг нэвтрүүлэх замаар одоогийн болон цаашид тасралтгүй нэмэгдэх ачааллыг бууруулж, зохиомлоор ачаалал үүсэхээс сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй байна.
- 1.6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөрдөгч, хэрэг бүртгэгч болон прокурорын эрх, үүргийн тэнцвэрийг хангах шаардлагатай байна. Хэрэг мөрдөн шалгах ажиллагаанд зөвшөөрөл өгөх эрхийг прокурорт шилжүүлсэн нь нэг талаас хүний эрхийг дээрдүүлэх, мөрдөгчид хуучин эрүүдэн шүүх аргаар хэргийг мөрддөг гэсэн хандлагатай холбоотой. Хуулиар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зөвшөөрлийн дийлэнх буюу 90 орчим хувь нь прокурорын байгууллагын эрх хэмжээнд тусгагдсан. Үүний улмаас мөрдөн

шалгах ажиллагаанд хугацаа алдах, бие даасан шуурхай ажиллагаа алдагдаж байна. Прокурорын ачаалал ихэссэн ч орон тоо нэмэгдээгүйгээс мөрдөгчдөд ачаалал үүсгэж байна. Иймд аль аль талаас нь сайтар анхаарч зохицуулах шаардлагатай.

**Санал:** Хуулийг хэрэгжүүлэх, бүтэц, зохион байгуулалт, нөөц бололцоог тооцоолох шаардлагатай. Механик ачааллыг бууруулах, цахим хэлбэрт шилжих замаар хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай. Хүний үндсэн эрхтэй холбогдохоос бусад тохиолдолд буюу иргэний үнэмлэхийн лавлагаа, хилээр орсон гарсан лавлагаа гэх мэт энгийн процесс ажиллагааг цахим сүлжээ ашиглан мөрдөгч бие даан хийх боломжтой. Үүнийг ялган зааглах хэрэгтэй. Зөвшөөрөл авдаг ажиллагааг биечлэн биш сүлжээ ашиглан хийх эрх зүйн зохицуулалт, дэд бүтцийг шийдэх нь зүйтэй.

- 1.7. Прокурор нь шүүх ажиллагаанд улсын яллагчаар оролцдог бөгөөд мөрдөн шалгах ажиллагаа эхлэх үеэс хяналт тавьж, удирдан чиглүүлж, хавтаст хэрэгт яллах талын нотлох баримтыг цуглуулж байгаа тул ЭХХШТХ-ийн 1.7 дугаар зүйлд заасан “Хэргийн бодит байдлыг нотлохын тулд мөрдөгч, прокурор хуульд заасан бүх арга хэмжээг авч яллагдагч, шүүгдэгчийг яллах, цагаатгах, ял хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдлыг эргэлзээгүй тогтооно” гэсэн заалттай зөрчилдөж байна. Иймд мөрдөн шалгах ажиллагааг бие даан, хараат бусаар явуулах хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, мөрдөгчид тодорхой хэмжээний эрхийг олгох нь зүйтэй. Эсхүл хуулийн анхны үзэл санаа болох прокурорын шатад хавтаст хэргийн материал ажиллагаанд байж, мөрдөгч зөвхөн даалгавраар ажиллагааг гүйцэтгэх үүрэгтэйгээр ажиллах хуулийн зохицуулалтыг бий болгох нь зүйтэй.

**Санал:** Хуулийн 4.2 дугаар зүйлд заасан прокурорын үүрэгт “мөрдөн шалгах ажиллагааны явцад цугларсан нотлох баримт бүхий хавтаст хэргийн материал прокурорт байна”, “гэмт хэрэг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагааны явцад гарсан аливаа шийдвэр, зөвшөөрлийн эрх зүйн үр дагаврын хариуцлагыг хүлээнэ” гэсэн нэмэлт заалтыг оруулах.

Санал хуваагдсан болно. 1/Гэмт хэргийг шүүхийн өмнө нотолж яллах чиг үүргийг хэрэгжүүлэгчийн хувьд прокурор нь мөрдөн шалгах ажиллагааг удирдан чиглүүлэх эрх мэдлийг хэрэгжүүлэх нь зүйн хэрэг буюу одоогийн хуулийн зохицуулалт тохиромжтой. 2/Мөрдөгчийн бие даасан байдал алдагдсан. Зөвхөн прокурорын даалгавар, чиглэлээр ажиллаж байгаа, түүнчлэн аливаа ажиллагааг явуулахын тулд байнга прокуророос зөвшөөрөл авч байгаа нь хэт хүнд сурталтай, хугацаа алдсан асуудал болж байна.

- 1.8. Мөрдөгч эрүүгийн хэрэг үүсгэж, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд таслан сэргийлэх арга хэмжээ авах зорилгоор яллагдагчаар татах санал гаргаж прокурорт хүргүүлэхэд хяналтын прокурорууд саналыг “14 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ” гэсэн байдлаар хандаж, шийдвэрээ шуурхай гаргахгүй байгаагаас шалтгаалан гэмт хэрэг үйлдсэн этгээд оргон зайлах, бусад этгээдтэй мэдүүлгээ нэгтгэх, хохирогчтой тохиролцох зэрэг хүндрэл учирч байна.

**Санал:** ЭХХШтХ-д заасан “боломжит богино хугацаа”-нд эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах тогтоол гаргах зохицуулалтыг УЕП-ын 2017 оны А/96 дугаар тушаалаар баталсан “Мөрдөн шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын ажлын аргачилсан заавар”-ын 14.8 дугаар заалтад тусгах, яллагдагчаар татах тогтоол гаргах хугацааг тодорхой зааж, сунгах бололцоотой хэлбэрээр хуульчлах шаардлагатай.

- 1.9. УДШ буюу хяналтын шатны шүүхэд ял нэмэх эрхийг олгосон нь буруу зохицуулалт юм. Дээд шатны шүүхээс ялыг хүндрүүлдэг байдал нь шүүхийн шийдвэрт гомдол гаргах, давж заалдах үндсэн эрхийг зөрчиж байна.

**Санал:** ЭХХШтХ-ийн 39.1 дүгээр зүйлийн 4, 40.8 дугаар зүйлийн 1.4-т заасныг өөрчлөх

- 1.10. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удааширсан, шаардлагагүй ажиллагаанууд нэмэгдсэн зэргийг сайтар судалж, залруулах шаардлагатай.
- 1.11. Хүүхэд хохирогчтой хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн байгууллага, ажилтны мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх боломжийг хаах, хугацаа алдах, субъектүүдийн хооронд маргаан, үл ойлголцох байдал бий болж байна. Тухайлбал, бэлгийн хүчирхийллийн хохирогч, бага насны хүүхдэд мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх гэхээр цагдаагийн байгууллага “мөрдөн байцаах ажиллагааны нууц” гэсэн нэрээр хаалт тавьж байна.
- 1.12. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдэд үзүүлэх үйлчилгээг Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээтэй уялдуулах нөхцөл, шаардлага ойлгомжгүй байна. Үүний улмаас Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар баталсан журам биелэх боломжгүй болж байна.
- 1.13. Хуульд өмгөөлөгчийн эрхийг тусгах нь өмгөөлөгчид эрх олгож байгаа явдал биш, харин хэргийн оролцогчийн өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангаж байгаа гэдэг талаас нь хандаж хуулийг боловсруулах шаардлагатай. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цагдаа, прокурор, шүүхийн байгууллагаас өмгөөлөгчтэй хамтран ажиллах, хэргийн товыг мэдэгдэх зэрэг дээр үйлчлүүлэгчээр дамжуулан харилцах тохиолдол байсаар байна. Цаашлаад шүүх хуралдааны товыг өмгөөлөгчтэй зөвшилцөлгүйгээр товлож, хүрэлцэн ирж чадаагүй тохиолдолд байлцуулахгүйгээр шүүх хуралдааныг явуулах, хүсэлт гаргасан тохиолдолд хүлээн авахгүйгээр шийдвэрлэж байгаа нь үйлчлүүлэгчийн Үндсэн хуулиар баталгаажсан эрхийг зөрчиж байгаа хэрэг юм. Мөн хэргийн материалтай танилцах боломжит хугацааг тогтоож өгөх шаардлагатай байна.
- 1.14. Давах, хяналтын шатны шүүх хуралдаанд оролцоход өмгөөлөгчдөд үг хэлэх хугацаа зааж байгаа нь өмгөөлөл хийх боломжийг хязгаарлаж байна. Өмгөөлөгчийн шүүх хуралдаанд оролцож, үг хэлэх хугацааг хуулиар хязгаарлаагүй байхад шүүхээс хуулийг буруу хэрэглэж, буруу жишиг тогтоосон.
- 1.15. Өмгөөлөгчид хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн үеэс эрх, үүргийг нь сануулаад хавтаст хэрэгтэй танилцуулах шаардлагатай. Мөн хүсэлт шийдвэрлэх хугацааг тодорхой болгох, хувь хүн, албан байгууллагын нууцтай холбоотойгоос бусдыг хувилж авах боломжоор хангах шаардлагатай байна.

1.16. Улсын өмгөөлөгчөөр хангуулахтай холбоотойгоор төлбөрийн чадваргүй иргэдэд асуудал тулгардаг. Тухайлбал, зайлшгүй өмгөөлөгч оролцуулах шаардлагатай хэрэг дээр амьжиргааны түвшнээс доогуур буюу улсын өмгөөлөгчөөр хангуулах эрхтэй гэдгийг тодорхойлдог хорооны тодорхойлолт нь хэр баталгаатай талаар эргэлзээ үүсдэг. Үүнтэй холбоотойгоор мөрдөгчдөд өмгөөлөгчөө сонгох эрхээр хангах ажиллагаанд шаардлагатай гарын авлага, өмгөөлөгчдийн холбогдох хаягийн жагсаалтыг гаргаж өгөх, тогтмол шинэчилж байх нь зүйтэй.

**Санал:** Хуулийн зохицуулалт гэхээсээ зохион байгуулалтаар шийдвэрлэж болох асуудал. Хуульд заасны дагуу төлбөрийн чадваргүй байдлыг хорооны даргын тодорхойлолтоор бус Төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэх учиртай.

1.17. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн товыг өмгөөлөгчид мэдэгдэхгүй байна. Шүүхийн хэлэлцүүлэг дээр үндэслэлгүйгээр түдгэлзүүлэх зэрэг хэрэглээтэй холбоотой алдаа дутагдлыг шийдэх саналтай байна.

1.18. Сэжигтэн яллагдагч төлбөрийн чадваргүй бол үнэгүй өмгөөлөгчөөр хангагдахаар заасан ч, хохирогч өмгөөлөгчөөр хангагдах боломжгүй хэвээр байгаа бөгөөд өмгөөлөгчийн зардлыг гаргуулах боломжгүй болсон. Иймээс хохирсон хүн нэмж хохироход хүрч байна. Хуучин хуульд өмгөөлөгчийн зардлыг шууд зардлаас нь тооцоод гаргадаг байсан. Үүнээсээ ухарчихсан. Хохирогчийн өмнөөс прокурор төлөөлөх зохицуулалтыг хуульд тусгасан байсан ч хассан нь ухралт болсон.

**Санал:** Тодорхой хэргийн хохирогчид үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх асуудлыг шийдвэрлэх.

Прокурор хохирогчийг өмгөөлөх нь чухал ч Тангарагтны шүүхтэй эсхүл Солонгос шиг прокурорын дэргэдэх мөрдөн байцаах газартай улсад энэ нь тохиромжтой. Манай улсын тухайд мөрдөх процесс нь өөр. Тэдгээр улсад бол сэжигтэн, яллагдагчийг нэг баг, хохирогч талаа нэг баг шалгаж, прокурор өөрийнхөө сэжигтэй гэж үзсэн үндэслэлээ шалгах бүрэн эрхтэй байдаг. Прокурор хоёр талаас ирсэн материалаа нийлүүлж шалгадаг. Түүнийгээ шүүх хуралд авч ороод танилцуулдаг. 2 талын өмгөөлөгч үнэн мөнийг олохын тулд мэтгэлцдэг. Манайд бол нэг мөрдөгч бүгдийг шалгадаг.

1.19. Хохирлыг яаж тооцох, үнэлэх, барагдуулах вэ гэдэг дээр механизм нь байхгүй байна. Тохиролцооны маягаар байцаан шийтгэх ажиллагааны аль нэг шатанд хэдэн төгрөг өгөлцөж авалцаад, баримт болгоод бичдэг, зарим тохиолдолд бичихгүйгээр шүүх рүү орж байна. Иймээс хохирол барагдуулалт дээр асуудал гардаг. Сэтгэл санааны хохирол бол бүр байхгүй. Зарим талаар энэ нь ухралт юм. Хохирогчид ээлтэй биш, түүнээс гадна хохирогчийг хэрхэн хамгаалах нь тодорхойгүй, эрүүгийн хэрэг үүсэхээс өмнөх шатны хамгаалалт байхгүй. Эрүүгийн хэрэг үүсэх үү, үгүй юу гэдэг шатанд нь хохирогчид дарамт шахалт үзүүлэх, айлгасан зэргээс болж, эрүүгийн хэрэг үүсдэггүй. Иймээс өмнөх шатны хамгаалалт маш чухал юм.

**Санал:** Хүчин, хүний наймаа, хүүхдийн эсрэг хүч хэрэглэсэн гэмт хэргүүд дээр хохирлыг төр хариуцаад, дараа нь буруутай этгээдээс гаргуулж авахаар зохицуулалт хийх нь зүйтэй.

- 1.20. Багш, судлаачид, ТББ-ын зүгээс хүний халдашгүй байх эрхэд халдах бол шүүхээс зөвшөөрөл авах ёстой гэсэн санал өгсөн ч хуульд тусгаагүй. Тухайлбал, хүний биеэс дээж авах бол нарийвчилсан зохицуулалтыг хуульд тусгаж, зөвшөөрлийг шүүх өгөх ёстой. Олон улсын жишгийг харахад ямар нөхцөлд, ямар дээж авах, дээжийг хэрхэн авах, хадгалах, устгах асуудлыг маш нарийн зохицуулсан байдаг. Гэтэл манайд тодорхой процессыг хуульд тусгаагүй тул хүний эрх зөрчигдөх магадлал өндөр байна.

**Санал:** Иймээс үүнийг шүүхэд эрхийг нь шилжүүлбэл яасан юм бэ, эсвэл давхар шүүхийн хяналт байх хэрэгтэй. Мөн ямар дээжийг прокурорын, ямар дээжийг шүүхийн зөвшөөрлөөр авах вэ гэдэгт нарийвчилсан зохицуулалт хэрэгтэй байна.

- 1.21. Өмнөх хуульд гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж зүйлчилдэг байсан бол одоо хөнгөн, хүнд гэж зүйлчилж байгаа. Цагдан хорих хугацааг хуучин сэжигтэн 14 хоног байсан бол одоо яллагдагчийг 30 хоног болгосон нь эрх зүйн байдлыг дордуулсан. Үүн дээр хүний эрхийг зөрчих асуудал гарч болзошгүй.
- 1.22. Шүүхээс яллагдагчийн эрх зүйн байдал дордоно гэж үзээд хуульд заасан хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял ногдуулах зохицуулалтыг мөрдөхгүй байна. Тухайлбал, хэд хэдэн нутаг дэвсгэрт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, хэргийг нь шийдвэрлэх явцад дахин өөр өөр хэргийн холбогдогч нэмэгдэж хэргийг хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял ногдуулах шаардлага үүсэхэд, шүүхийн шийдвэр хэрэгтнийг дахин гэмт хэрэг үйлдэх нөхцөлийг бүрдүүлж байна. Анхны хэрэг нь шүүхээр шийдвэрлээгүй байхад дараагийн гэмт хэрэг гараад ирэхэд нэмж, нэгтгэх бололцоо хуульд байхгүй байгаа нь асуудал үүсгэж байна. Үүний улмаас гэмт хэрэг тус бүрт ял оногдуулах хуулийн үндсэн концепц алдагдаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удааширч байна.
- 1.23. Хилийн хоригийн тухай зохицуулалтыг сайтар судалж, бодит байдалд хэрхэн шийдэгдэж байгааг судалж үзэх шаардлагатай. Өмгөөлөгч хэрэг үүсэхээс өмнө нотлох баримтаар буруутайг нь нотолж, хилийн хориг тавих хүсэлт гаргах үед эрүүгийн хэрэг үүсгэхээс өмнө хилийн хориг тавих боломжгүй гэдэг үндэслэлээр хэрэгтэнд оргон зайлах бололцоо үүсгэж байна.
- 1.24. Хуулийн шинэтгэл эрчимтэй хийгдэж байгаа боловч хүний эрхийг дээрдүүлэх чиглэлд хангалттай биш, илүүтэй яллах талын эрх ашигт түлхүү үйлчилж байна. Үүнийг нэг жишээ нь, гэрчийн мэдүүлэг авахдаа мөрдөгч, сэжигтэн, гэрчид ял тулгах, тулгаж асуух явдал тохиолдсоор байна. Мөн мөрдөн байцаалтын шатанд хэргийн оролцогчдыг хэргийн материалтай танилцуулах ажил зайлшгүй биш, сайн дурын үндсэн дээр явагдаж байгаа бөгөөд яллагдагчийг хэргийн материалтай танилцах нөхцөл боломжоор хангахгүй байна.
- 1.25. Шүүхийн шатанд гэрч оролцуулах хүсэлт гаргах боломжгүй байна. Учир нь гэрчийн мэдүүлэг нотолгооны нэг хэрэгсэл мөн боловч шүүхийн зүгээс гэрчээс мөрдөн шалгах ажиллагааны явцад мэдүүлэг аваагүй бол шүүхийн шатанд оролцуулах боломжгүй гэж



үзэж байгаа нь учир дутагдалтай. Иймд шүүхийн шатанд шинэ гэрчийг байцааж, мэдүүлэг авах эрх зүйн боломжийг бүрдүүлэх нь зүйтэй.

#### Эсрэг санал:

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шатанд гэрч оролцуулах санал тавьж шийдвэрлүүлэх боломж хуульд нээлттэй тул энэ нь шаардлагагүй.

- 1.26. Шүүх хурал хойшлуулах бүхий л нөхцөл байдал үүсэж, шүүгдэгчид таслан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай үед өмгөөлөгч хүсэлт гаргахад тодорхойгүй байдал бий болсон. Учир нь уг тохиолдолд шүүхийн зүгээс яллагдагчийн өмгөөлөгчөөр хүсэлт гаргах бус шүүгдэгчийн өмгөөлөгчөөр хүсэлт гаргахыг шаардаж байгаа ба энэ нь өмгөөлөгчийн эрх, үүргийг тодорхойгүй болгож байна.
- 1.27. Эрүүгийн хэргийг сэргээх зохицуулалтад “хуулийг ноцтой зөрчсөний улмаас” гэсэн зохицуулалт нэмж тусгах шаардлагатай байна.
- 1.28. Шүүх дээр гарын үсэг зуруулаагүй нотлох баримт очиж байгаа нь нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэхгүй байгаа ч нотлох баримтад гарын үсэг зуруулна гэсэн зохицуулалт байхгүй байгаа нь эргэлзээ үүсгэж байна.
- 1.29. Бодит байдал дээр хуулийн зохицуулалт тодорхой байхад хуулийг хэрэглэдэггүй асуудал тулгарч байна. Иймд мөрдөгч, прокурор, шүүгчдийн сэтгэлгээг өөрчлөх шаардлагатай. Учир нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэт яллах талыг барьдаг хандлага байсаар байна. Албан хаагчдад зориулсан сургалтыг хуулийн хэрэглээ тал руу нь хандуулж явуулах шаардлагатай.
- 1.30. Шүүхийн шатанд үндэслэлгүйгээр хэрэг түдгэлзүүлэх тохиолдолд аль ч тал гомдол гаргах боломжгүй болж байна.
- 1.31. Гэмт хэрэг үйлдэх үед олсон эд материал, мөнгөн хөрөнгө г.м зүйлсийг яллагдагчаар татахын өмнө хурааж авч болно. Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах зорилгоор нээлттэй заалт оруулах шаардлагатай.
- 1.32. Эрүүгийн мөрдөгч болон цагдаагийн бусад албадын алба хаагчид нь халаасны хулгайн гэмт хэргийг илрүүлж, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлан мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий албан хаагчид хүлээлгэн өгөхдөө нотлох баримтыг дутуу цуглуулж, гэмт үйлдлийг бүрэн баримтжуулдаггүйгээс хэргийг нотлох, гэм бурууг тогтооход хүндрэл үүсэж байна.

**Санал:** Цагдаагийн алба хаагчийн нийтлэг чиг үүргийн хүрээнд эрүүгийн мөрдөгч болон цагдаагийн бусад албадын алба хаагчдыг хойшлуулшгүй ажиллагааг гүйцэтгэх чиглэлээр мэргэшүүлэх шаардлагатай. Хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээд эд зүйлийг хямд үнээр ломбард, хувь хүмүүст барьцаанд тавьж борлуулдаг болсон тул гэмт хэргийн замаар олдсон эд зүйлийг худалдан авч байгаа ченж, барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхлэгчдийг тогтоож үндсэн хэрэг шийдэхийг хүлээлгүй Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйл /Мөнгө угаах/- ээр зүйлчлэн, үйлдлийг тусгаарлан шийдвэрлэдэг болох нь зүйтэй.

- 1.33. Хулгайлах гэмт хэргийг илрүүлэх зорилгоор ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461 дүгээр ангид цагдан хоригдож байгаа яллагдагчийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахаар бусад газар, хэлтсээс дуудан ирүүлэх шаардлагатай үед хяналтын прокурор зөвшөөрлийн хуудас олгохгүй байгаа нь гэмт хэрэг илрүүлэхэд хүндрэл учруулж байна.

**Санал:** ЭХХШТХ, Мөрдөн шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын ажлын аргачилсан зааврын дагуу мөрдөгчийн саналыг үндэслэн, зөвшөөрлийн хуудсыг даруй хүргүүлж хэвших

- 1.34. Прокурор гаргасан шийдвэрээ гардуулах хууль зүйн үүрэгтэй байгааг шүүх шиг албан ёсоор мэдэгддэг зохицуулалттай адилтгах шаардлагатай.
- 1.35. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд анхан болон дунд шатны шүүх хэдий хугацааны дотор хэргээ танилцуулах талаар зохицуулалт тодорхойгүй байна.
- 1.36. Таслал (,) болон цэгтэй таслал (;) хоорондын утга агуулгын ялгааг тайлбарлах шаардлагатай байна. Мөн хуульд “ба”, “бөгөөд”, “эсхүл” зэрэг ойлголтыг ашиглах, эдгээрийг хэрхэн ойлгох тайлбарыг тодорхой болгох.

**Санал:** Хууль ойлгомжтой бөгөөд “модон” буюу сунжирсан хэллэгээс татгалзах нь зүйтэй. Монгол хэлний дүрэм, найруулгын үүднээс хандах нь зохимжтой биш.

- 1.37. Шүүх хуралдааны үеэр яллагдагчийн эрх, үүргийг шүүгдэгчид танилцуулах нь зүйтэй юу?

**Санал:** Тус хуулийн 7.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа шүүгдэгчид энэ бүлэгт заасан эрх, үүрэг нэгэн адил хамаарна” гэж заасан нь шүүгдэгчид яллагдагчийн эрх, үүргийг танилцуулахад ямар нэгэн зарчмын асуудалгүй болно..

- 1.38. Түдгэлзүүлсэн хэргийг сэргээсэн, зарим гэмт үйлдлийг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй хуульчилснаар дүүргийн нэг мөрдөгчид өнөөдөр 100 орчим хэрэг хуваарилагдсан тоон үзүүлэлт гарчээ. 100 хэрэгт нэг мөрдөгч хэрхэн хүрч ажиллах вэ? Нэг прокурорын хяналт тавих хэргийн тоо өссөнөөр яллагдагчаар татах тогтоол, мэдэгдэх хуудсаа бичиж амжихгүй дүр төрх ажиглагдаж байна.
- 1.39. Яллагдагчаар татах, цагдан хорих, хязгаарлалт тогтоох, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх, таслан сэргийлэх арга хэмжээ авах саналыг прокурор, шүүгч шийдвэрлэх хугацааг боломжит хугацаагаар тогтоохгүй бол яллагдагчаар татах тогтоол 14 хоногт бичигдэж байгаа талаар мэдсэн, таслан сэргийлэх арга хэмжээ авах санал гаргасан талаар олж мэдсэн сэжигтэн этгээд оргон зайлах боломжтой. Зарим нэр бүхий этгээдүүд хилээр гарч явсаар байна.
- 1.40. Прокурор эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах санал гаргасан тохиолдолд хянах, шийдвэр гаргах хугацааг хуульчлах шаардлагатай.



## Хоёр. Тусгай асуудал

- 2.1. Сэжигтнийг томьёолох шаардлагатай байна. Сэжигтний асуудал байхгүй явж байгаад сүүлд нь сэжигтний өмгөөлөгч, баривчлагдсан сэжигтэн гэж гарч ирээд байгаа нь хуулийг нэг мөр ойлгож хэрэглэхэд хүндрэл учруулж байна. Аливаа гэмт хэрэгт сэжигтнээр татаж байгаа этгээдийг шинэ хуулиар гэрчээр асуугаад, хууль сануулаад, худал мэдүүлэг өгч болохгүй гэгчхээд, дараа нь буцаагаад яг тэр үндэслэлээр яллагдагчаар татаж байна. Энэ нь Үндсэн хуульд заасан өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх гэсэн зарчимтай зөрчилдөж байгаа болно. Иймд сэжигтэн гэсэн томьёолол орж ирвэл, дагаад эрх, үүрэг нь тодорхой болох боломжтой.

**Санал:** Яллагдагчаар татах санал хүргүүлснээс хойш шийдвэрлэх хүртэл сэжигтэн гэж томьёолох шаардлагатай. Энэ хугацаанд сэжигтний тодорхой эрхийг хязгаарлах боломжтой байхаар хуульчлах. Гэмт хэрэгт буруутгагдсан этгээдийн эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай. Хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.3-т сэжигтнийг тодорхойлох, томьёолох, эрх, үүргийг тусгах шаардлагатай.

- 2.2. Хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.6-д “өмгөөлөх тал” гэж тодорхойлсон нь учир дутагдалтай байгаа тул өмгөөлөгч гэдэг нэр томьёогоор солин, тодорхойлох шаардлагатай. Учир нь “өмгөөлөгч”-ийг Үндсэн хуульд тусгасан ч уг хуульд тодорхойлж өгөөгүй байгаа нь эрх зүйн харилцаанд өмгөөлөгчийн эрх, үүргийг тодорхойгүй байдалд оруулж байна. Тухайлбал, насанд хүрээгүй болон насанд хүрсэн этгээдийг өмгөөлөх эрх, үүрэг ялгаатай.

**Санал:** 1.4 дүгээр зүйлийн 1.16 дугаар хэсэгт заасан “өмгөөлөх тал” гэдгийг “өмгөөлөгч” гэсэн нэр томьёогоор өөрчилж, эрх, үүргийг нь тодорхойлох.

- 1.41. Хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.5 дугаар хэсэгт тусгагдсан “томилогдсон өмгөөлөгч” гэсэн тодорхойлолт тодорхойгүй байдал үүсгэж байна. Өмгөөлөгчөө өөрөө сонгоно гэсэн хэдий ч томилолтын өмгөөлөгч томилохоор заасан. Нэг этгээд хүн амины хэрэгт сэжиглэгдээд ирсэн, байцаалт авах гэтэл өмгөөлөгч байхгүй байсан учраас мөрдөгч таньдаг өмгөөлөгчөө дуудаад шууд оролцуулчихсан. Тухайн этгээдтэй ярилцах явцад энэ хэргийг үйлдээгүй, намайг зодсон гэсэн. Энэ хэрэг УДШ хүртэл явж, тухайн этгээдэд ял шийтгэл оногдуулсан. Хуулинд өөрөө өмгөөлөгчөө сонгоно гэдэг атал мөрдөгч өмгөөлөгч авчирч оролцуулсан нь хууль зөрчсөн үйлдэл, өмгөөлөгчөө сонгох эрх нь зөрчигдсэн байна гээд байхад бүх шатны шүүх авч хэлэлцээгүй, өөрөөс нь өөр гэмт хэрэг үйлдсэн эсэхийг нотлох хүн байгаагүй, хийгээгүй гэдгээ нотолж чадаагүй гэсэн үндэслэлээр, хуучин хуулиар шийдэгдсэн. Ер нь 2 цаг хүртэлх хугацаанд өмгөөлөгч нь ирээгүй бол томилолтын өмгөөлөгч оролцуулна гэсэн нь 2 цагийн дотор тэр хүний нөхцөл байдалтай өмгөөлөгч танилцаж, хууль зүйн туслалцаа үзүүлж чадах уу гэсэн эргэлзээ үүсгэж байна. Энэ нь нөгөө талаас иргэний өмгөөлөгчөө сонгох эрхийг хязгаарлаж байна. Ямар өмгөөлөгч авах вэ, мэргэшсэн байх уу гэдэг нь тухайн хүний сонголтын асуудал. Өмгөөлөгчийн лавлагаа байх ёстой, сонгох эрх нь нээлттэй байх ёстой.

**Санал:** Томилогдсон өмгөөлөгчийн зохицуулалтыг нарийвчлах. Өөрөөр хэлбэл хэн өмгөөлөгчийг томилох нь мөрдөгчийн дурын асуудал бус тогтоосон дүрэм, журмын дагуу байх зохицуулалтыг бий болгох. Томилогдсон өмгөөлөгч сэжигтэн, яллагдагчтай уулзах, хэрэгтэй танилцах боломжит хугацаагаар хангагдахаар зохицуулах шаардлагатай.

- 2.3. Хуулийн 1.5 дугаар зүйлд заасан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж болохгүй тохиолдол” гэсэнд хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн хэргүүдэд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх арга хэмжээ авах заалт тусгагдаагүй байгаа нь шаардлагагүй, зохиомол ажиллагаа хийгдэхэд хүргэж байна.

**Санал:** Иймд хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт “хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн хэргүүдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, хэргийг хэрэгсэхгүй болгох” тухай зохицуулалтыг тусгах. Эсхүл дээрх зохицуулалтыг материаллаг хууль болох Эрүүгийн хуульд тусгах.

- 2.4. Хуулийн нэр томъёоны тодорхойлолтын 1.4 дүгээр зүйлийн 1.7-д туссан “Даруй” гэж боломжит богино хугацааг гэснийг 11.1-тэй уялдуулан, тоон илэрхийллээр гаргах нь зүйтэй. “Боломжит богино хугацаа” гэсэн нь нэр томъёоны тодорхойгүй байдал үүсгэж, боломжит хугацааг хязгаарлаж байна. Иймд “даруй” гэснийг “боломжит хугацаа” өөрчлөн тодорхойлон, “богино” гэснийг хасах шаардлагатай.
- 2.5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.6 дугаар зүйлд тусгагдсан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хууль ёсны байх гэсэн зарчим нь хуулийн заалтыг чанд сахина гэсэн үг билээ. Гэтэл бодит байдал дээр хэргийн харьяаллыг тогтоосон прокурорын шийдвэргүйгээр хэргийг шийдвэрлэсэн тохиолдлууд гарсаар байна.
- 2.6. Хуулийн 1.14 дүгээр зүйлийн 2-т хууль зүйн туслалцаа авах, өмгөөлүүлэх боломж, нөхцөл, цаг хугацаагаар хангагдана гэсэн боловч хугацаа нь тодорхойгүй байгаа тул хугацааг тодорхой болгох шаардлагатай.
- 2.7. Хуулийн 2.2 дугаар зүйлийн 6-д шүүхийн харьяаллыг тогтоохдоо гэмт хэрэг нь хэд хэдэн шүүхийн харьяалах нутаг дэвсгэрт үйлдэгдсэн бол сүүлчийн гэмт хэрэг үйлдэгдсэн газрын шүүх хянан шийдвэрлэхээр заасан нь 2.3 дугаар зүйлийн 1-д заасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг нутаг дэвсгэрийн харьяаллаар явуулна гэсэнтэй зөрчилдөж байна.
- 2.8. Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний халдашгүй эрх болох захидал харилцааны болон орон байрны халдашгүй дархан байх эрхэнд халдах зөвшөөрлийг прокурор дангаараа өгөх эрхтэй байхаар хуульчилжээ.

**Санал:** Шүүгчийн зөвшөөрлөөр энэ үйл ажиллагааг явуулж байхаар зохицуулах

- 2.9. Хуулийн 4.1 дүгээр зүйлийн 2.15-д “Прокурор нь мөрдөн шалгах ажиллагаа явуулах даалгаврыг өгөх, түүний биелэлтийг хангуулах” гэж заасан ба мөрдөн шалгах ажиллагааны явцад болон шүүхээр шийдвэрлүүлэхээр прокурорын хяналтад шилжүүлсэн хэрэгт нэмэлт ажиллагаа хийлгүүлэхээр бичсэн прокурорын даалгаварт мөрдөгчөөс санал бичиж буцаах эрхийг хуулиас хассан нь хэргийн бодит үнэнийг тогтоох үйл ажиллагаа хэт нэг талыг

барьсан ажиллагаа хийлгүүлэх, нотлогдсон ажиллагааг дахин хийлгэж, зохиомол ажлын ачаалал үүсгэх гэх мэт зарим тохиолдолд гажуудал үүсэж болзошгүй байна.

**Санал:** Хуулийн 6.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг /Мөрдөгчийн эрх/-т “прокурорын даалгаварт санал бичих” гэсэн заалт нэмж оруулах. Эсхүл уг хуулийн 6.2 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт “прокурорын даалгавраар мөрдөн шалгах ажиллагаа явуулах, үндэслэлгүй гэж үзвэл дээд шатны прокурорт санал бичих” гэж нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай.

2.10. Хуулийн 5.1 дүгээр зүйлийн 4-т урьдчилан бичгээр мэдэгдэх үүрэгтэй юм шиг харагдаж байна.

**Санал:** Үүнийг хасах.

2.11. Хуулийн 5.2 дугаар зүйлийн 5-д төлбөрийн чадваргүй хохирогч өмгөөлүүлэх эрхээр хангуулах тухай нэмж оруулах шаардлагатай.

2.12. Хуулийн 5.2 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан өмгөөлөгчийг сонгох тухай хэсэгт “сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч тогтоосон хугацаанд өмгөөлөгч сонгож аваагүй бол тухайн ажиллагаанд томилогдсон өмгөөлөгчийг оролцуулна” гэдэгт “тогтоосон хугацаа” гэдэгт хэдий хугацааг тооцох, хэрхэн тооцох нь ойлгомжгүй байдал үүсгэж, хэргийн оролцогчийн эрхийг зөрчих асуудал үүсгэж, мөрдөн байцаагч өөрийн дураар өмгөөлөгч томилох, тулгах асуудал үүсгэж байна.

**Санал:** Хуульд “тогтоосон хугацаа” гэсэн ойлголтыг тодорхойлох.

2.13. Хуулийн 6.1 дүгээр зүйлийн 4 дүгээр хэсэгт “тагнуул, цагдаа, авлигатай гэмцэх байгууллагын албан хаагчийн үйлдсэн гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах харьяаллыг прокурор тогтооно” гэснийг илүү тодруулах шаардлагатай байна. Хэргийн харьяалал тогтоохтой холбоотой асуудалд прокурор хариуцлага хүлээх ёстой боловч одоогийн байдлаар уг асуудлыг УЕП-ын 2015 онд гаргасан тушаалаар шийдвэрлэж байна.

**Санал:** Иймд тус заалтад прокурор тогтоохдоо “прокурор тогтоол гаргана” гэж нэмж тусгах

2.14. Хуулийн 6.2.3 дахь хэсгийн зохицуулалтын улмаас мөрдөгчөөс прокурорт, прокуророос орон нутгийн прокурорт, орон нутгийн прокуророос тухайн газрын мөрдөгчид гэх мэтээр сунжирч, хэргийн шалгалтын явцыг удаашруулахад хүргэж, хэргийг илрүүлж шийдвэрлэх шуурхай байдал алдагдаж байна.

**Санал:** Иймд мөрдөгчийн даалгаврыг сэргээж 6.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “мөрдөгч даалгавар бичиж холбогдох байгууллагад хүргүүлнэ” гэж оруулах.

2.15. Хуулийн 6.2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “тусгай мэдлэг эзэмшсэн мөрдөгч энэ хуульд заасан шинжээчийн эрхийг хэрэгжүүлж, магадалгаа гаргаж болно” гэж заасныг

27.11 дүгээр зүйлийн мөрдөгчийн магадалгаа гэснээр журамлаж байна. Гэтэл шүүхийн шинжилгээний тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 6 дугаарт “мөрдөгчийн магадалгаа” биш “шинжилгээний магадалгаа” гэж журамласан байна. Иймд ЭХХШТХ болон Шүүхийн шинжилгээний тухай хуулийн уялдаа холбооны асуудлыг нэг мөр болгох, өөрөөр хэлбэл шинжилгээний магадалгаа эсхүл мөрдөгчийн магадалгаа гэсэн хоёр нэр томъёоны аль нэгээр ойлгох шаардлагатай. Түүнчлэн 6.2 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан эрхийг хэрэгжүүлэх мөрдөгч нь шинжилгээ хийхээр томилогдсон шинжээчтэй хамтран ажиллаж болно” гэсэн ч тухайн тусгай мэдлэг эзэмшсэн мөрдөгч, шинжээч хэрхэн, ямар журмаар хамтран ажиллах нь тодорхой бус байна. Мөн ЭХХШТХ-ийн 9.2 дугаар зүйлд зааснаар шинжээчид “магадалгаа гаргана” гэсэн эрх байхгүй байгаа нь ойлгомжгүй байдал үүсгэж байна.

**Санал:** Иймд хамтран ажиллах журмыг ЭХХШТХ болон Шүүхийн шинжилгээний тухай хуулийн аль нэгээр нь журамлах, зохицуулах асуудлыг шийдэх.

1.42. Хуулийн 9.1 дүгээр зүйлд зааснаар гэмт хэргийн улмаас учирсан эд зүйл, хөрөнгийн үнэлгээг шинжээч томилж, дүгнэлт гаргуулахаар хуульчилсан. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирлын үнэлгээг хувийн үнэлгээний байгууллагаар тогтоолгож байгаа бөгөөд оролцогчид үнэлгээг хүлээн зөвшөөрөхгүй, дахин үнэлгээ тогтоолгох хүсэлт гаргадаг. Дээрх тохиолдолд оролцогчид үнэлгээний зардлыг гаргахаас татгалздаг бөгөөд мөрдөгч нарт үнэлгээний төлбөрийг төлөх зардал байдаггүй, гаргах боломжгүй байдгаас шалтгаалан хэргийн шалгалт удаашрах байдал үүсдэг. Тухайлбал, эд зүйлийн үнэлгээ гаргуулахад хоёр тал үнэ дээр тохиролцох боломжтой байхад зайлшгүй гуравдагч байгууллагаар үнэлгээ хийлгэж байгаа нь санхүүгийн болон цаг хугацааны зохиомол чирэгдэл учруулж байна.

**Санал:** Тохиролцсон ч шүүх хуралдааны явцад хохирогч бодлоо өөрчлөх тохиолдол гардаг энэ нь эргээд ажиллагаанд саад учруулдаг. Хэрвээ талуудын тохиролцоог мөрдөгч хөдөлшгүй баталгаажуулж, түүнийг шүүх шууд үнэлдэг бол боломжтой

2.16. Хуулийн 9.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт гэрчийг тодорхойлохдоо “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг гэрч гэнэ” хэмээн тодорхойлсон нь хэрэг мөрдөлтийн явцад гэрчээс авсан мэдүүлэгт үндэслэн хэрэгт татах, мөн МУ-ын Үндсэн хуульд тусгагдсан ойр дотнын хүнийхээ эсрэг болон өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх гэсэн эрхийг нь зөрчихөд хүргэж байна. Түүнчлэн хуульд “гэрч” гэдэг этгээдэд хэнийг хамруулан ойлгох талаар ойлголт дутмаг байна. Тиймээс хуучин хуулийн “гэрч” гэсэн тодорхойлолтыг эргэж харах, олон улсын жишиг хууль тогтоомжид байгаа гэрчийн тодорхойлолтыг харьцуулан судлах замаар “мэдүүлэг өгөхөөс санаатайгаар зайлсхийх” гэдэг томъёоллыг өөрчлөхгүй бол гэрч заавал хариуцлага хүлээхээр болоод байна.

**Санал:** Хуулийн 9.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт гэрчийг тодорхойлсон тодорхойлолтод “тухайн хэрэгт холбогдолгүй этгээдийг хэлнэ” гэж нэмж оруулах. Эсхүл “өргөдөл, гомдолд тусгагдсан, яллагдагчаар татагдах нь ойлгомжтой байгаа хүнийг гэрчээр тооцож асуухгүй байх”, мөн “гэрчээс мэдүүлэг авахдаа гэр бүл, ойр дотнын хүнийхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг танилцуулж, гарын үсэг зурж баталгаажуулна” гэдгийг хуульд тусгах.

- 2.17. Прокурорын тухай хуулийн 10.1.1 дүгээр зүйлд “мөрдөгч санал, өмгөөлөгч хүсэлт гаргасан” гэж хуульчилсан нь зэрэгцүүлсэн хэм хэмжээ гэж ойлгогдоно. Гэтэл ЭХХШТХ-д мөрдөгчийн санал гаргах тухай ойлголт хуульчлагдаагүй гэсэн үндэслэлээр мөрдөгчийн хууль зүйн үндэслэл бүхий саналуудыг дээд шатны прокурорууд хянан үзэхгүй орхигдуулж байна.

**Санал:** Иймд прокурорын үндэслэлгүй даалгаварт санал бичих эрхийг хуульчлах.

- 2.18. Хуулийн 10.2 дугаар зүйлийн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгч дахин оролцож болохгүй үндэслэл”-ийн 2 дугаар хэсэгт “Энэ хуулийн 3.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан асуудлыг хянан шийдвэрлэсэн шүүгч анхан шатны, давж заалдах, хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй” буюу цагдан хорионы асуудлыг шийдсэн шүүгч хэргийг шийдвэрлэх боломжгүй байгаа нь бодит байдалд шүүхийн орон тоо хүрэлцэхгүй, ажлын ачаалал их байгаа үед хэргийг шийдвэрлэхэд хүндрэл учруулж байна. Иймд уг тохиолдолд шүүгч шийдвэрлэх боломжтой байхаар зохицуулалтыг тусгаж, 10.2 дугаар зүйлийн 2 дэх хэсгийн заалтыг хасах шаардлагатай байна.
- 2.19. Тус хуулийн 11.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг тооцох, санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална” гэсэн ч одоог хүртэл журамлаагүй байна. Үүний улмаас шүүхийн шийдвэр гарахаас өмнө зарцуулагдаж буй зардлыг тухай бүр хэрхэн шийдвэрлэх талаар тодорхойгүй байдал үүсэж, шүүхээр гэм буруутай нь тогтоогдоогүй байхад мөрдөн шалгах ажиллагааны зардлыг хэргийн оролцогч нараас гаргуулж хууль зөрчих асуудал тулгарч байна. Шинжээч томилох зэрэг зайлшгүй зардал гарахаар байхад зардал батлагдаагүйн улмаас ажил удааширч байна.

**Санал:** Мөрдөн шалгах ажиллагааны явцад гарч буй зардлыг тухай бүр улсын төсвөөс гаргуулж, шүүхийн шийдвэр гарсны дараагаар гэм буруутай этгээдээс зардлыг нэгдсэн байдлаар гаргуулж авах зохицуулалтыг яаралтай батлах шаардлагатай.

- 2.30. “Нууц”-ын хэрэг гэсэн хуульд байхгүй ойлголт практикт бий болсон. Нууцын хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах тусгай журам байгаа эсэх нь тодорхойгүй байна. Хуулийн 11.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хавтаст хэрэг нь хэрэгт тусгасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шийдвэр, баримт бичиг, хэрэгт хавсаргасан бусад баримт бичиг, зүйлээс бүрдэнэ” гэж хуульчилсан байтал нууц мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд цугларсан баримтыг бус зөвхөн мөрдөгчийн магадалгааг хэрэгт хавсаргах, нууцад хамаарах хэргийг нууцаас гаргах гэх мэт олон асуудалтай тулгарсаар байна. Эрүүгийн хэрэг өөрөө төрийн нууцад хамаарч байгаа тул танилцуулах асуудлыг Төрийн болон албаны нууцын тухай хуульд нийцүүлэх шаардлагатай.

2.31. Хуулийн 12.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Мөрдөгч нь гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, яллагдагчийг мэдүүлэг авах, шийдвэр танилцуулах, мөрдөн шалгах ажиллагаанд оролцуулахаар дуудан ирүүлж болно. Мөрдөгчийн дуудсанаар хүрэлцэн ирээгүй нь албадлага хэрэглэх, хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй.” гэж хуульчилсан. Сэрдэгдсэн этгээд, яллагдагч, шүүгдэгчдээс мөрдөгчийн дуудсанаар ирэхгүй хүндрэл учруулах, мөрдөгчийг үл тоох, эсэргүүцэх зэргээр явуулж буй ажиллагаанд саад учруулж байна.

**Санал:** Дуудан ирүүлэх эрхийг мөрдөгчид олгох зорилгоор “мөрдөн шалгах ажиллагааны оролцогчдыг мөрдөгч, прокурор, шүүхийн мэдэгдэх хуудсаар дуудна” гэж өөрчлөх, дуудсан хүн ирээгүй бол албадан ирүүлэх зохицуулалт шаардлагатай.

2.32. Хуулийн 12.3 дугаар зүйлд албадан ирүүлэх оролцогчийг нэрлэхдээ сэжигтнийг орхигдуулсан.

2.33. Хэрэг бүртгэлтийн шатанд алга болоод байгаа тул энэ үе шатанд таслан сэргийлэх арга хэмжээ авах хэрэгтэй байна. Хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1-д яллагдагчаар татсан тохиолдолд таслан сэргийлэх арга хэмжээ авахаар заасан тул гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авч, буруутай этгээдийн үйлдлийг нотлох баримтаар тогтоох хүртэл хэрэг бүртгэлтийн шатанд тухайн этгээд оргон зайлах, дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэл гарч, хохирогчийн эрх зөрчигдөж байна.

**Санал:** “хэрэг бүртгэлтийн шатанд шаардлагатай тохиолдолд таслан сэргийлэх арга хэмжээ авч болно” гэж нэмэлт оруулах.

2.34. Мөн 14.1 дүгээр зүйлийн 1.1-д заасан таслан сэргийлэх арга хэмжээний төрөлд “хувийн баталгаа гаргах” тухай зохицуулалт нь бодит байдалд хэрэгжүүлэхэд учир дутагдалтай байна. Ялангуяа ажилгүй хүнд тохиромжгүй. Тиймээс ажилгүй хүнд ямар таслан сэргийлэх арга хэмжээ авах вэ гэдэг асуудлыг тодорхой болгох шаардлагатай. Иймд өмнөх хуулийн “хувийн батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээ”-г нэмж оруулах шаардлагатай байна. “Хувийн баталгаа” нь заавал ажил эрхэлдэг, оршин суух хаягтай байхыг шаарддаг. Хувийн батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээ байхгүйгээс яллагдагч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад дуудсан цагт ирэхгүй оргон зайлах, дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэл гарч, хохирогчийн эрх зөрчигдөж байна. Байгууллага, иргэний батлан даалтад өгснөөр гэм буруутай этгээдийн үйлдлийг ах дүүс, ойр дотнын хүмүүс мэдэх, оргон зайлах, дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх ач холбогдолтой.

2.35. Хуулийн 14.5 дугаар зүйлд хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авахтай холбоотойгоор яллах дүгнэлт үйлдэх үед оргон зайлж, улсын хилээр гарчихсан тохиолдолд, орж ирэх үед нь авах арга хэмжээ тодорхойгүй байгааг тодорхой болгох нь зүйтэй.

2.36. Хуулийн 14.9 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэгт “гэмт хэрэг дахин үйлдэх талаар үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа” гэсэнд “дахин” гэж орсон нь хууль зүйн утга агуулгын хувьд зохимжгүй байна.

**Санал:** “дахин” гэсэн үгийг хасах



- 2.37. Цагдан хорих үндэслэлийг хуучин хуульд байсан байдлаар хуульчлах. Одоо оргон зайлахыг завдсан, оргон зайлсан, оролцогч, бусад оролцогч нарыг дарамталсан, сүрдүүлсэн дахин гэмт хэрэг үйлдэх үндэслэл бүхий баримт байгаа гэх мэтээр гүйцэтгэх ажлын үр дүн давхар шаардсан нь мөрдөгч бүхэн нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулах боломжгүй үед бодит байдалд нийцээгүй шалгуур болсон. Цагдан хорих үндэслэлд яллагдагчийн хувийн байдлыг харгалзан үзэх талаар нэмж тусгах шаардлагатай.
- 2.38. Хулгайлах гэмт хэрэг үйлдсэн яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах саналаа прокурорт гаргаж, шүүхэд даруй хүргүүлдэг боловч шүүхээс хуулийн 14.9 дүгээр зүйлийн 1.4 хэсэгт заасан “гэмт хэрэг үйлдэх талаар үндэслэл бүхий баримт мэдээлэл байгаа” гэх үндэслэлийг “ирээдүйд дахин үйлдэхээр төлөвлөсөн гэмт үйлдлийн талаарх үндэслэл бүхий баримт мэдээлэл” гэж буруу ойлгож, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахгүй байх тохиолдол шүүхэд их байна.

**Санал:** Хуулийн 14.9 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлийг өөрчлөх, хүнд гэмт хэрэг үйлдсэн, удаа дараагийн үйлдлээр хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах талаар хуульд өөрчлөлт оруулах.

- 2.39. Хуулийн 14.10 дугаар зүйлийн 4-т цагдан хорих хугацааг тогтоохдоо өмнөх ялын цагдан хоригдсон хугацааг сүүлд хийсэн ялын хугацаатай нэгтгэн тооцож байгааг өөрчлөх шаардлагатай. Дөнгөж ялын хугацаагаа дуусгаж гараад л дахин гэмт хэрэгт холбогдож, хугацааг өмнөх ялын цагдан хоригдсон хугацаатай нэгтгэн тооцож, ял завших асуудал гарч байна.
- 2.40. Яллагдагчийг цагдан хорих саналыг 24 цагт шүүх шийдвэрлэх нэрээр пүрэв гарагт өгсөн санал шийдвэрлэгдэхгүй, шүүх 24 цагаар ажиллахгүй байгаагаас үүдэн шүүхийн зөвшөөрлөөр хийгдвэл зохих ажиллагаанууд хойшлуулшгүй ажиллагааны хүрээнд хийгдэж хуулийн үзэл санаа, агуулгаас ухарсан практик тогтож эхэллээ.

**Санал:** Шүүх 24 цагаар ажиллах эсхүл шүүгчийн зөвшөөрөлгүй баривчлах хугацааг 72 цагаар тогтоох. Нэг хүнийг баривчлах шийдвэр гаргасан бол 6 цагийн дотор хувийн байдал тогтоох, үүний дараа 8 цаг хүртэл хугацаагаар мэдүүлэг авдаг. 2-3 сэжигтнийг баривчлах, хойшлуулшгүй ажиллагааны явцад нэгжлэг, үзлэг хийхэд 48 цаг хангалтгүй байна.

- 2.41. Хуулийн 14.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгож, суллагдсан яллагдагчид урьд нь цагдан хоригдсон үндэслэлээр дахин цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахыг хориглоно” гэсэнтэй холбоотойгоор “өмнө цагдан хоригдсон нөхцөл арилсан” гэдгийг хэрхэн тодорхойлох талаар зохицуулалт шаардлагатай байна.
- 2.42. Яллагдагчид авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх бол хуулийн ямар зүйл заалтыг удирдлага болгох талаар тусгайлсан хуулийн заалтгүй байна.
- 2.43. Хуулийн 14.13 дугаар зүйлийн 4-д шүүхийн хэлэлцүүлэгт яллагдагчийн өмгөөлөгч ирээгүй бол томилогдсон өмгөөлөгч оролцуулж болно гэснийг яллагдагч тал хүсэлт гаргаагүй тохиолдолд өмгөөлөгч оролцуулахгүй байж болно гэсэн байдлаар өөрчилж болно. Энэ

тохиолдолд цагдан хорих хэлэлцүүлгийн товыг яллагдагч талд мэдэгдэх тухай нэмж оруулах нь зүйтэй.

- 2.44. Цагдан хорих шүүх хуралдаанд тодорхой үндэслэлүүдтэй нь танилцах боломжийг нээж өгөх хэрэгтэй.
- 2.45. Хуулийн 16.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн зохицуулалт нь тус хуулийн 16.1 дүгээр зүйлийн 7-д заасан зарчимтай зөрчилдөж байна. Энэ нь Монгол Улсын нэгдэж орсон олон улсын гэрээг мөн зөрчиж байна.

**Санал:** 16.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг бүхлээр нь хүчингүй болгох

- 2.46. Хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх зохицуулалт нь гэмт хэрэгт холбогдсон этгээдэд хэргээ хялбаршуулсан журмаар шийдүүлэхийг тулгахад хүргэж байгаа нь хуулийн зорилтыг гажуудуулж байна.
- 2.47. Хялбаршуулсан журмаар хэргийг шийдэх тохиолдолд шүүх хурлын товыг урьдчилан мэдэгдэх заалт хэрэгжихгүй байна. Хэрэг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхээр шүүхэд өгөхөд цагийг шууд тулгаж мэдэгдэж байна. Тухайлбал, 5 дахь өдөр өгсөн хэргийг Даваа гарагт дуудаад тэдэн цагт бэлэн бай, 72 цагийн дотор хянан хэлэлцэнэ гээд үүрэгдчихдэг. Гэтэл шүүх хурлын танхим хүрэлцээгүйгээс хүлээсээр байгаад тухайн өдрийн ажлын цаг дуусаж, хурал өдөртөө багтахгүй, хуульд заасан хугацаанд хэрэг шийдэгдэхгүй тохиолдол гарч байна.

**Санал:** Заал, танхимын хүрэлцээг нэмэгдүүлэх.

- 2.48. Хуулийн 17.5 дугаар зүйлд хугацаа сунгах тухай оруулж, хугацааг 14 эсхүл 30 хоногоор сунгахаар хуульд тусгах.
- 2.49. Хуулийн 17.6 дугаар зүйлийн “Шүүх хуралдаанд хохирогч, шүүгдэгч, прокурор, өмгөөлөгч хүрэлцэн ирээгүйн холбогдол” гэсний 2 дахь хэсэгт заасан “Өмгөөлөгч, прокурор хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд шүүх хуралдаанд оролцоно” гэсэн заалт бодит байдалд хуурамч баримт, тэр дундаа эмнэлгийн бичиг хуурамчаар үйлдэж, санаатайгаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахад хүргэж байна. Иймд хүндэтгэн үзэх шалтгааны нотлох баримтыг гаргаж өгөх ажиллагаанд илүү нарийвчилсан зохицуулалт хийх, мөн санаатайгаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан бол хариуцлага тооцох арга хэмжээ авдаг зохицуулалт бий болгох шаардлагатай.
- 2.50. Монгол Улс гэмт хэрэгт холбогдсон этгээдэд өөрөөр нь хэрэг хүлээлгэдэг онолоос татгалзаад тодорхой хугацаа өнгөрч байгаа үндэслэлийг харгалзан тус хуулийн 17.4 дүгээр зүйлийн 4.2 хэсэгт заасан шүүх хуралдаанаар харгалзан үзэх нөхцөл байдлын жагсаалтаас “гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа сайн дураараа хүлээн зөвшөөрсөн эсэх” гэснийг хасах шаардлагатай байна.
- 2.51. Хуулийн 17.4, 17.5 дугаар зүйл нь хэрэглээнд ойлголтын зөрүүг үүсгэж, практикт өөр өөрөөр хэрэглэх асуудал гарч байна. 17.5 дугаар зүйл буюу зарим гэмт хэргийг хялбаршуулсан журмаар шүүхэд шилжүүлэхээр зарим хэрэгт 17.4 дугаар зүйлд заасан үндсэн шинжийг шаардаж байна. Татгалзахаар хэргийг буцаадаг. Энэ 2 заалтыг хольж хэрэглээд байгаа нь практикт хүндрэл учруулж байна.

Санал: 17.5-ыг хасах

- 2.52. Хуулийн 17.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт хорих ялын доод хэмжээ 8-аас дээш жилийн ялтай хэргүүдийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхгүй гэсэн нь хурдан шийдэх боломжтой хэргүүд дээр удаашрал үүсгэж байна. Мөн тус хуулийн 17.5 дугаар зүйлд тусгагдсан зохицуулалт нь 17.4 дүгээр зүйлтэйгээ зөрчилдөж байна. Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр хасагдсан гэмт хэргийг 17.5 дугаар зүйлд дурдсан байгааг хасах.
- 2.53. 18 дугаар бүлгийн “Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох хэрэг хянан шийдвэрлэх” тухай зохицуулалтад “өсвөр нас” гэсэн ойлголтод хамрагддаг 14-18 насныхны үйлдсэн хэргийг уг зохицуулалтаар шийдвэрлэж байгаа боловч 18-21 насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид энэ ажиллагаа хэрхэн явагдаж байгаа нь тодорхойгүй байна. Мөн үүний улмаас практикт 21 настай хэрэгтэнд сургалт хүмүүжлийн арга хэмжээ авах эрх зүйн үндэс бүрдэж, насанд хүрээгүйчүүдийн хорих ангид хорих асуудал мөн үүсэж байна. Иймд 18-21 насны сэжигтэн, яллагдагчийн үйлдсэн хэрэгт энэ бүлэгт заасан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа заавал явуулах эсэхийг тодорхой болгох. Эсхүл 18 – 21 насны этгээдийн үйлдсэн хэргийг хэрхэн шийдвэрлэх талаар хуульд тусгайлан зохицуулалт оруулах шаардлагатай байна.
- 2.54. Эрүүгийн хуулийн 21.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “хэрэг шалган шийдвэрлэх” гэж орсон нь нэр томьёоны хувьд хуулийн уялдаа холбоог алдагдуулж байна.

Санал: “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх” гэдгээр солих

- 2.55. Хуулийн 21.5 дугаар зүйлийн “Хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг шийдвэрлэх” тухай заалтад түргэн муудах, гэмтэх, устах, эсхүл хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл чанар нь муудах хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хэрхэн шийдвэрлэх талаар тусгасан боловч түүнээс бусад эд мөрийн баримтыг хэрхэн шийдэх талаар зохицуулалт тодорхой бус байна. Иймд эд мөрийн баримтыг хэрхэн шийдвэрлэх талаар зохицуулалтыг тодорхой болгож, хуульд тусгах шаардлагатай.
- 2.56. Хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Мөрдөгч ...хүний биеэс шинжилгээнд зориулж биологийн дээж авах, ...мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах ажиллагааг ... прокурорын зөвшөөрлөөр явуулна” гэж заасан нь мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулахад хүндрэл үүсгэж байна.
- 2.57. Хуулийн 22.1 дүгээр зүйлийн 9-д байгаа товыг өмгөөлөгчид боломжит хугацаанд урьдчилан мэдэгдэх заалтыг хэрэглэхгүй байна.
- 2.58. Хуулийн 22.3 дугаар зүйлд заасан прокурорын зөвшөөрөл бичгээр гарахаар байгаа нь Прокурорын тухай хуулийн 34.4.1, 34.2-т заасан буюу баталгаажуулах хэлбэртэй байна гэсэнтэй зөрчилдөж байна. УЕП-ын баталсан зааварт үүрэн телефоны оператор компаниас мэдээлэл авах тухай зөвшөөрлийг олгохдоо албан бичигт зөвшөөрсөн тухай тэмдэглэл гарын үсэг зурах хэлбэрээр олгохоор байдаг. Ийнхүү авсан мэдээллийг шүүх дээр нотлох баримтаар үнэлээд ороод ирэнгүүт, 22.1 дүгээр зүйлийн 3 дах заалт, 22.3 дах хэсэгт заасан прокурорын зөвшөөрлөө гаргаагүй байна гэж зөрчил үүсэхээр байна.
- 2.59. Хуулийн 22.4 дүгээр зүйлд мөрдөгч прокурорын зөвшөөрлөөр хийх ажиллагааг хойшуулшгүйгээр хийсэн бол 72 цагийн дотор нотлох баримт, тайлбарыг хүргүүлэх

талаар өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Мөрдөгч 7 хоногийн “баасан”, “бямба” гаригт хойшлуулшгүй тохиолдолд мөрдөн шалгах ажиллагааг прокурорын зөвшөөрөлгүй явуулж, энэ тухайгаа 24 цагийн дотор прокурорт тайлбар бичиж хүргэх асуудал нь амралтын өдрүүдэд таарч хугацаа алдах, мөрдөгч хууль зөрчсөн асуудалд орох эрсдэлтэй байна.

- 2.60. Нэгжлэг хийх үндэслэл тогтоогдож зарим албан тушаалтны ажлын байр, гэрт очиход харуул хамгаалалт бүхий байр луу нэвтрүүлдэггүй. ЭБШХ-ийн 133.3-т хураан авах, нэгжлэг хийх ажиллагаанд саад учруулбал албадан гүйцэтгэх зохицуулалт байсан. Гэтэл ЭХХШТХ-д дээрх зохицуулалт хуульчлагдаагүй тул нэгжлэг хийх явцад саад учруулбал орон байрны хаалгыг албадан буюу хүч хэрэглэн нээх албадлагыг шууд хэрэгжүүлэх боломжгүй болж байна. Энэ нь гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, гэмт үйлдлийг шалгахдаа бусдын орон байр, тээврийн хэрэгсэл, ажлын байр, агуулах сав, эзэмшил газарт нэвтрэн орох, ач холбогдол бүхий баримт, мэдээллийг гаргуулан авах мөрдөгчийн эрхийг хязгаарласан. Гэмт хэрэг үйлдсэн хүн гэртээ ороод хаалгаа түгжээд суувал хэрхэн баривчлах нь тусгайлсан зохицуулалтгүй байна.

**Санал:** Гэмт хэргийг таслан зогсоох, гэмт хэрэг үйлдсэн хүнийг мөрдөн хөөж баривчлах, эсхүл гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй нөхцөл байдал үүссэн гэх үндэслэл бүхий сэжиг байгаа, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах бодит аюул байгаа, эрэн сурвалжлагдаж байгаа хүн оргосон, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялан, хоригдлыг мөрдөн хөөж баривчлах, сэжиг бүхий этгээд оргон зайлах, гэмт хэргийн ул мөр, эд мөрийн баримт устах, үрэгдэх бодит аюул тулгарсан бол орон байранд нэвтрэн орох эрхийг хуульчлах шаардлагатай.

- 2.61. Хуулийн 24.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Мөрдөгч байгууллага, хувь хүний нууцтай холбоотой эрүүгийн хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл, баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтан, хүнээс прокурорын зөвшөөрлөөр гаргуулан авна”. Мөн 2 дахь хэсэгт “Мөрдөгч энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад мэдээлэл, баримт бичгийг байгууллага, албан тушаалтан, хүнээс прокурорын зөвшөөрлөөр гаргуулан авч болно” гэж заасан нь хүний эрхийг хамгаалж байгаа хэдий ч мөрдөн шалгах ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Иргэний мэдээлэл, ял шалгах, хөрөнгийн лавлагаа авах, авто машин эзэмшигчийн лавлагаа гаргуулах бүрт прокуророос шийдвэр гаргахаар хуульчилсан нь үнэхээр оновчтой бус зохицуулалт болжээ. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүний өмч хөрөнгө, хувийн байдал тогтоолоо гэж үзэхэд мөрдөгч мэдээлэл авах санал бичнэ. Уг саналыг прокурор хуулж бичээд тогтоол бичиж ирүүлнэ. Уг зөвшөөрлийг албан тоотоор лавлагаа, мэдээлэл авах газарт илгээнэ. Энэ үйл явдалд зарцуулагдах цаг хугацаа, үргүй зарцуулагдсан цаас их гарч байна. Энэхүү хуулийн заалт нь Прокурорын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасан “Хуульд заасан тохиолдолд прокурор зөрчил шалган шийдвэрлэх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагааны явцад зөвшөөрөл өгнө”, 34.2 дахь хэсгийн “Прокурорын зөвшөөрөл нь албан тушаалтны шийдвэрийг зөвшөөрч батлах хэлбэртэй байна” гэсэн заалттай зөрчилдөж тогтоол гаргаж байгаа нь мөрдөн шалгах ажиллагааны шуурхай байдалд сөргөөр нөлөөлөх үндэслэл болсон. Одоо зарим байгууллагын эрх бүхий албан тушаалтан хуулийг буруу тайлбарлан “...байгууллага, хувь хүний нууцтай холбоотой бус ...” мэдээллийг гаргуулан авах үед ч прокурорын зөвшөөрөл шаарддаг болсон. Иймд төрийн байгууллагаас хэрэгт ач холбогдол бүхий баримт бичиг гаргуулан авах бол зөвшөөрөл шаардаад байгаа зохицуулалтыг өөрчлөх.

**Санал:** Уг зүйлийн 2 дахь хэсгийг хасаж, мөрдөгч бие даан явуулах бололцоог хангах.

- 2.62. Хилийн хориг тавихад өмгөөлөгч оролцуулна гэснийг ашиглаж өмгөөлөгч нь шалтаг хэлээд олддоггүй, хугацаа хождоод, хурал хойшлуулаад байна. Хурал хойшилсноор тухайн хүн хилээр амжаад гарах нөхцөл үүсээд байна.

**Санал:** Прокурорын саналыг үндэслэж, хилийн хориг тавьдаг болгох

- 2.63. Давж заалдах шатны шүүх оногдуулсан ялын хэмжээнд тухайн зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх эрхтэй байхаар зохицуулсан. Гэтэл жишээ нь, 27.10 дугаар зүйлд заасан хэргүүд дээр нэмэгдэл ял хэрэглэхгүйгээр албадлагын арга хэмжээг тэнсээд, тэнссэн хугацаанд тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хязгаарласан хэрэгт прокурор эсэргүүцсэн үед давж заалдах шатны шүүх өөрчлөлт оруулж, нэмэлт ял оруулж байна.
- 2.64. Хуулийн 27.6 дугаар зүйлийн 3-д байгаа хэд хэдэн шинжээч хамтран оролцож, санал зөрсөн бол саналаа бичиж, дүгнэлтэд хавсаргахаар байгааг анхаарах шаардлагатай.
- 2.65. Хуулийн 29.2 дугаар зүйлээр хэрэг бүртгэлийн явцад хэргийг нэгтгэх боломжгүй байхаар зохицуулсан.
- 2.66. Хуулийн 29.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “хэд хэдэн яллагдагч нэг, эсхүл хэд хэдэн гэмт хэргийг хамтран үйлдсэн, эсхүл нэг яллагдагч хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн бол үйлдэл тус бүрд нь эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, мөрдөн байцаалт явуулна” гэснийг цагдаа, прокурорын байгууллага практик ажиллагаанд мөрдөхгүй байгаа нь шүүхийн шатнаас хэргийг буцаах шалтгаан болж байна.
- 2.67. Хэрэг бүртгэлтийн хэргээс хэрэг, үйлдэл тусгаарлах ойлголт хуульчлагдаагүй, мөрдөн шалгах ажиллагаа явуулж байхад хэд хэдэн гэмт хэргийн шинж бүхий үйлдэл тогтоогддог. Хуулийн 29.2 дугаар зүйлд зөвхөн мөрдөн байцаалтын явцад хэрэг тусгаарлах, нэгтгэхээр хуульчилсан нь оновчтой бус зохицуулалт болсон. Иймд тусгаарлах ойлголтыг хуульчлах шаардлагатай.
- 2.68. Мөрдөгч нь яллагдагч, шүүгдэгчийн эд хөрөнгийг 30.7 дугаар зүйлийн 1-д заасан нөхцөлд битүүмжлэхээр хуульчилсан. Энэ нь 16.1 дүгээр зүйлтэй зөрчилдөж байна.
- 2.69. Хуулийн 30.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт гомдол мэдээллийг хүлээн авснаас хойш 5 хоногт шийдвэрлэхээр заасан бөгөөд хуульд хугацаа сунгах асуудлыг тусгаагүйгээс гомдол мэдээллийг 5 хоногийн дотор шийдвэрлэхэд Монгол шиг уудам газар нутагтай улсад хэт давчуу хугацаа байна. Энэ нь АТГ-ын мөрдөгч Баян-Өлгий аймгаас ирүүлсэн гомдлыг аваад шалгах, шийдвэр гаргах бүү хэл очиж ч амжихгүй хугацаа юм. Мөн гомдол мэдээллийг 5 хоногийн дотор шийдвэрлэх боломжгүй буюу шүүх эмнэлгийн дүгнэлт гараагүй г.м. тохиолдолд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах санал гаргаж, дүгнэлт гарсны дараа прокуророос дахин хэрэг үүсгэж ирүүлж байгаа нь иргэдийг чирэгдүүлж байна.

**Санал:** Гомдол мэдээлэл хүлээн авсан бол шууд хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, эсхүл шалгах хугацааг 14 хоног болгох шаардлагатай, эсхүл “Мөрдөн шалгах ажиллагаа явуулах албаны дарга шаардлагатай тохиолдолд гомдол мэдээлэл шалгах хугацааг 14 хоног хүртэл сунгаж болно” гэсэн заалт оруулах

2.70. Хуулийн 30.7 дугаар зүйлийн 1.3 дахь заалтад зөвхөн гэрчээс мэдүүлэг авах тухай зохицуулалт орсон тул гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл хүлээн аваад хохирсон иргэнийг гэрчээр байцааж, шаардлагатай нотлох баримт цуглуулж гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй болохыг тогтоосны дараа /гэмтлийн зэрэг тогтоосон шүүх эмнэлгийн дүгнэлт гарсны дараа гэх мэт/ дахин хохирогчоор тогтоон мэдүүлэг авч байгаа нь иргэдийг чирэгдүүлж, зохиомол ачаалал үүсгэж байна.

**Санал:** Хуулийн 30.7 дугаар зүйлийн 1.3 дахь заалтаас “гэрчээс” гэснийг хасаж “мэдүүлэг авах” гэж өөрчлөх.

2.71. Хуулийн 31.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Яллагдагчаар татах тогтоолыг прокуророос авсан даруй мөрдөгч, сэжигтний хувийн байдлыг тогтоох, яллагдагчаар мэдүүлэг авах ажиллагааг 6 цагийн дотор явуулна” гэсэн нь хэрэг бүртгэлтийн шатанд сэжигтэнд таслан сэргийлэх арга хэмжээ авах заалт хуульд заагаагүй тул хэргийн холбогдогч гадуур чөлөөтэй явдаг. Яллагдагчаар татах тогтоол прокуророос батлагдсаны дараа мэдүүлэг авах тохиолдолд хаана байгаа газар нь тодорхойгүй, эсхүл алслагдсан сум, суурин газар руу мөрдөгч, хэсгийн төлөөлөгч очих хугацаа 6 цагаас хэтэрч хууль зөрчих явдал гарч байна.

**Санал:** Иймд “Яллагдагчаар татах тогтоолыг прокуророос авсан даруй мөрдөгч, сэжигтний хувийн байдлыг тогтоох, яллагдагчаар мэдүүлэг авах ажиллагааг даруй явуулна” гэж өөрчлөлт оруулах.

2.72. Хуулийн 31.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “Шүүхийн зөвшөөрлөөр баривчилж саатуулах хугацаа 48 цагаас хэтэрч болохгүй” гэж заасан нь сэжигтнийг 7 хоногийн “баасан” гаригт баривчилж саатуулсан тохиолдолд “ням” гаригт хугацаа дуусаж, үргэлжлүүлж цагдан хорих шаардлагатай хүнийг ажлын өдөр болтол мөрдөгч хаана байлгах нь тодорхойгүй бөгөөд баяр амралтын өдрүүдэд 24 цагийн дотор шүүх шийдвэрлэнэ гэсэн заалт хэрэгжих боломжгүй байна.

**Санал:** Шүүхийн зөвшөөрлөөр баривчилж саатуулах хугацааг нэмэгдүүлж, 72 цаг болгон өөрчлөлт оруулах.

2.73. Хуулийн 31.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Мөрдөгч сэжигтнийг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу баривчилсан бол 24 цагийн дотор шүүх шийдвэрлэнэ” гэж заасан нь сэжигтнийг баяр, амралтын өдрүүдэд баривчилсан бол шүүхэд хэрхэн мэдэгдэж, шийдвэрлүүлэх нь ойлгомжгүй байна.

**Санал:** Шүүхэд мэдэгдэх боломжит хугацааг харгалзан үзэж, баяр, амралтын өдөр баривчилсан бол дараагийн ажлын өдөр шийдвэрлэхээр хугацааг оруулах



- 2.74. Хуулийн 31.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “мөрдөгч баривчлагдсан сэжигтнээс мэдүүлэг авахын өмнө түүнд ямар хэрэгт холбогдуулан мэдүүлэг авч байгаа талаар танилцуулж, дараах эрхийг тайлбарлана” гэж заасны “баривчлагдсан сэжигтэн” гэсэн нь баривчлагдаагүй сэжигтнээс мэдүүлэг авахтай холбоотой зохицуулалтыг тусгах шаардлага үүсгэж байна.

**Санал:** Иймд 31.11 зүгээр зүйлээс “баривчлагдсан” гэдэг үгийг хасах

- 2.75. Хуулийн 31.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэх үндэслэлд “гэрч, хохирогч байхгүй” гэж нэмэх шаардлагатай.
- 2.76. Хуулийн 32.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “мөрдөгч мөрдөн шалгах бүх ажиллагааг хийж дууссан, хэргийн бодит байдлыг бүрэн нотолж тогтоосон гэж үзвэл ялагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид хавтаст хэргийн материалтай танилцахыг мэдэгдэнэ” гэсэн нь өмгөөлөгчид хэргийн материалтай танилцах хангалттай хугацаа, боломж олгохгүй байна.

**Санал:** Хуульд “хэргийг мөрдөн байцаалтын хугацаа дууссаныг мэдэгдсэнээс хойш 14 хоногийн дотор хэргийн оролцогчдод хавтаст хэргийн материалтай танилцуулна, шаардлагатай тохиолдолд дахин 14 хоногоор сунгана” гэж тусгах.

- 2.77. Хуулийн 32.1 дүгээр зүйлийн 3 дах заалтад хэргийн материалтай танилцах хугацааг боломжит хугацаанд тогтоох тал дээр анхаарах хэрэгтэй.
- 2.78. Мөрдөн байцаалт явуулж дууссан хэргийн материалыг прокурор 14 хоногийн дотор хянах ба зайлшгүй тохиолдолд зохих дээд шатны прокурор 14 хүртэл хоногоор нэмж сунгаж болно гэсэнд 32.4 дүгээр зүйлийн 2 дах заалтад нийцүүлэн хязгаарлалт тогтоох шаардлагатай.
- 2.79. Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан гомдол гаргах 32.7 дугаар зүйлийн 1 дэх заалтад мэдсэнээс хойш 1 сарын дотор гомдол гаргах эрхтэй гэж оруулах нь зүйтэй
- 2.80. Хуулийн 32.10 дугаар зүйлийн 6-д ялах дүгнэлтийг зөвхөн прокурор ялагдагчид гардуулна гэснийг 11.9 дүгээр зүйлтэй уялдуулан прокурорын байгууллагын ажилтан гэж өөрчлөх шаардлагатай. Өмнө нь ялагдагч ялах дүгнэлтийг энэ прокуророос аваагүй гэснээс болж хууль зөрчсөн гэдэг үндэслэлээр буцаагдах тохиолдол гарч байсан жишээ байна.
- 2.81. Хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6 дугаар хэсэгт заасан “шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр ялах дүгнэлтэд заасан гэмт хэргийн хүрээнд талуудын гаргасан хүсэлт, гомдлоор, эсхүл шүүгч өөрийн санаачилгаар дараах асуудлыг хянан хэлэлцэж шийдвэр гаргана” гэсэн нь гэм бурууг хэлэлцэх шүүх хурлаас хэргийг буцаах тохиолдол үүсгэж байна. Түүнчлэн 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн зохицуулалт нь уг хэсэгтэй зөрчилдөж байна.

**Санал:** “Гэм бурууг хэлэлцэх шүүх хурлаас хэргийг буцаахыг хориглоно” гэсэн заалт нэмж оруулах. Эсхүл гэм буруугийн асуудлаар анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхээс хэргийг буцаадаг, оролцогчийн эрхийг хангаагүй үндэслэлээр буцаадаг тодорхой тохиолдлуудыг зааж өгөх

2.82. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгтэй холбоотой зарчмын зөрүүтэй 2 байр суурь байна. Үүнд:

**Дэмжих санал:**

Талууд урьдчилсан хэлэлцүүлэг явуулах тухай хүсэлт гаргасан тохиолдолд шүүх хүсэлтийг хүлээн авахгүйгээр шийдэх эрхтэй учир урьдчилсан хэлэлцүүлгийг хэвээр авч үлдэх нь зүйтэй. Иймд шүүхээс шаардлагатай тохиолдолд урьдчилсан хэлэлцүүлэг явуулах тухай хүсэлтийг 33.1 дүгээр 1.2 дахь “хэргийг прокурорт буцаах” заалтад үндэслэн хүлээн авахгүйгээр шийдээд явах нь зүйтэй.

**Хасах санал:**

Уг ажиллагаа нь шүүх ажиллагааны бэлтгэлийг хангах зориулалттай байсан ч практикт улам чирэгдэл учруулж байна. Урьдчилсан хэлэлцүүлэг явуулах тухай хүсэлт ирсэн ч аль нэг тал хүрэлцэн ирэх боломжгүй нөхцөл, тохиолдол үүсэж, гол зорилго нь биелэхгүй байна.

- 2.83. Хуулийн 33.1 дүгээр зүйлийн 12 дах заалт, 34.1-тэй зөрчилдөж байна.
- 2.84. Боломжит богино хугацаа гэдэг үгийн оронд тодорхой хоног тавьж өгөх хэрэгтэй байна.
- 2.85. Хуулийн 33.4-т Шүүх хэргийг түдгэлзүүлэх үндэслэлийг 31.14.1-ийн үндэслэлтэй нийцүүлэх.
- 2.86. Хуулийн 34.1 дүгээр зүйлийн 2 дах хэсэгт заасан “Шүүх гэм буруугийн талаар маргасан шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон шийдвэрийнхээ үндэслэлийг танилцуулсны дараа түүнд Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг хэлэлцэх шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулна” гэснийг практик ажиллагааг түргэн шуурхай явуулах үүднээс зохих өөрчлөлтийг оруулах шаардлагатай байна. Иймд уг заалтад “гэм буруу, хохирлын талаар маргаагүй тохиолдолд шүүх хуралдааныг нэг үе шаттайгаар явуулна” гэж өөрчлөлт оруулах шаардлагатай.
- 2.87. Хуулийн 34.19 дүгээр зүйлийн 1.2-ыг “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан” гэж өөрчлөх шаардлагатай.
- 2.88. Хуулийн 34.19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг “энэ зүйлийн 1.1-д заасны дагуу шүүх хэрэгсэхгүй болгосон хэргийг хэрэг бүртгэлтэд буцаана”, мөн 36.9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй гэх үндэслэлээр цагаатгах тогтоол гарсан бол холбогдох шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг прокурорт буцаана” гэсэн заалтууд нь хэрэглээнд ойлгомжгүй байдал үүсгэж байгааг тодруулах шаардлагатай байна.
- 2.89. Хуулийн 35.21 дүгээр зүйлийг 27.8 дугаар зүйлийн 2-той нийцүүлж, дахин шинжээч томилох асуудлыг оруулах шаардлагатай.
- 2.90. Шүүхээс гэм буруутайд тооцсон үндэслэлийг танилцуулаагүй тохиолдолд тогтоол нь үндэслэлгүй болох шаардлагатай гэж үзэж байна. Ингэхдээ 39.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “анхан шатны шүүх гэм буруутайд тооцсон үндэслэлийг шүүх хуралдаанд танилцуулаагүй” гэсэн заалт нэмж оруулах шаардлагатай.

2.91. Хуулийн 39.9 дүгээр зүйл, 40.8 дугаар зүйлийн дагуу хэргийг буцаах тохиолдолд анхан шатны шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт хэргийг буцаах шаардлага үүсч байгаа нь хүндрэл учруулж байна.

**Санал:** Давах болон хяналтын шатны шүүх шаардлагатай тохиолдолд хэргийг нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцаах боломжтой зохицуулалтыг хуульд нэмж тусгах.

2.92. Хуулийн 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 болон 1.5 дугаар хэсгийг нэг мөр тайлбарлаж, ойлгомжтой болгох шаардлагатай.

2.93. Хуулийн 40.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Энэ хуулийн 39.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг гардуулсан, эсхүл хүргүүлснээс хойш 30 хоногийн дотор хяналтын журмаар гомдол, эсэргүүцэл гаргаж болно” гэж заасан нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц хэт сунжрах нөхцөлийг бий болгож байна. Иймд тус заалтад тусгагдсан хугацааг “14 хоног” болгон өөрчлөх нь зүйтэй.

### Хуульчид

1. П.Адьяасүрэн
2. Ц. Алдархишиг
3. С.Алминцэцэг
4. Ц.Алтангадас
5. Т.Алтантуяа
6. Н.Анхбаяр
7. Ч.Анхбаяр
8. Н.Арвинтариа
9. А.Ариунзаяа
10. Н.Баасанбат
11. Ц.Баасандэлгэр
12. А.Баатар
13. Д.Бадам
14. С.Байгалмаа
15. А.Бакыт
16. Д.Батгэрэл
17. А.Батгэрэл
18. Б.Батзориг
19. Г.Батнасан
20. Б.Бат-Орших
21. Д.Батсүх
22. П.Баттулга
23. Ж.Бат-Эрдэнэ
24. М.Баярсайхан
25. Д.Баярсүрэн
26. Б.Баярхүү
27. Т.Баясгалан
28. Ч.Болдбаатар
29. Д.Болдсайхан
30. Г.Болормаа
31. Д.Бурмаа
32. Г.Бямбадорж
33. Б.Галсанжамц
34. Б.Ганбаатар
35. Т.Ганбат
36. Б.Ганболд
37. В.Ганболд
38. А.Ганзориг
39. М.Гансүвд
40. С.Гансэлэм
41. Б.Гантулга
42. Б.Гэрэлмаа
43. Ц.Дайрийжав
44. С.Дангаасүрэн
45. Б.Дашдондов
46. Д.Дашцэрмаа
47. Г.Должинсүрэн
48. Б.Дуламсүрэн
49. Ш.Ербол
50. Б.Жавхланбаяр
51. Ч.Жадамба
52. У.Жамбацэрэн
53. Б.Жаргал
54. Ч.Жаргалбаатар
55. И.Золзаяа
56. М.Лхагвасүрэн
57. Б.Мангилик
58. Б.Манлайбаатар
59. Н.Манлайбаатар
60. Т.Мөнхбадрах
61. Т.Мөнхдалай
62. Т.Мөнх-Оргил
63. Ц.Мөнхчимэг
64. Ц.Мөнх-Эрдэнэ
65. Г.Наранбаатар
66. Т.Наранбат
67. Х.Наранзул
68. П.Нарантуяа
69. С.Номынбаясгалан
70. Э.Нэмэхжаргал
71. Э.Нямбилэгт
72. Х.Одбаяр
73. Н.Онон
74. Б.Отгон
75. Ч.Отгонсүрэн
76. В.Отгончимэг
77. Ц.Оч
78. М.Очирбат
79. С.Оюун
80. Д.Оюунбат
81. П.Оюунтунгалаг
82. Б.Оюунцэцэг
83. Г.Оюунцэцэг
84. П.Өлзийбаяр
85. М.Өлзийцэцэг
86. С.Өмирбек
87. У.Содбаяр
88. Б.Соёл-Эрдэнэ
89. Д.Сүнжид
90. Б.Сүрмандах
91. Ж.Тамир
92. М.Төрмөнх
93. Я.Туул
94. Ч.Түвшинжаргал
95. Т.Урангэрэл
96. Б.Уранцэцэг
97. Б.Уранчимэг
98. Ц.Уртнасан
99. Г.Халиунаа
100. Б.Хандмаа
101. Л.Хаш
102. В.Хосбаяр
103. З.Хүрэлбагана
104. Г.Цацрал
105. Б.Цогтбаатар
106. Д.Цэндсүрэн
107. С.Цэрэндорж
108. С.Цэцэгмаа
109. С.Цэцэгсүрэн
110. Х.Чекара
111. И.Чимэдбадам
112. М.Чинбат
113. Д.Чинзориг
114. М.Чинзориг
115. О.Чулуунцэцэг
116. Б.Энхбат
117. С.Энхбат
118. Ц.Энхбаяр
119. Д.Энхболд
120. Н.Энхжаргал
121. С.Энхзаяа
122. С.Энхмаа
123. Ж.Энх-Од
124. Л.Энхсайхан
125. З.Энхтайван
126. Ж.Энхтуяа
127. Н.Энхтуяа
128. Х.Эрдэм-Ундрах
129. Г.Эрдэнэбат
130. Б.Эрдэнэ-Очир
131. М.Эрдэнэсайхан
132. Э.Эрдэнэсувд
133. Л.Эрхзаяа

### Төрийн бус байгууллагын ажилтнууд

134. А.Балдангомбо
135. Б.Баттогтох
136. Б.Баярмаа
137. Б.Баярмаа
138. Г.Ганбаясгах
139. Б.Жавзанхүү
140. Д.Мягмардорж
141. Б.Онон
142. Ч.Сэмжидмаа
143. Т.Цогзолмаа
144. П.Цэвээн
145. С.Цэндбаатар

Дугаарыг эрхэлсэн: **Б.ХИШИГСАЙХАН**  
ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер

Хаяг: Жамъян гүний гудамж - 5/1  
Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар - 14240  
Монгол Улс

Утас: 976-11-313207  
Факс: 976-11-324857  
Вэб: www.forum.mn  
И-мэйл: osf@forum.mn

### Хамтрагч байгууллага:



### МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБОО

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай-7, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 4 давхар, 403 тоот  
Утас: 70116007, 70116065  
И-мэйл: info@mgllbar.mn